


Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2023 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн  
А/336 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



**МОД, МОДОН МАТЕРИАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫГ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

**1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:**

Хяналт шалгалт хийх байгууллага	
Шалгуулагч иргэн, хуулийн этгээдийн нэр	
Регистрийн дугаар	
Объектын нэр, хаяг, солбицол	
Байгуулагдсан огноо	
Үйл ажиллагааны чиглэл	
Дарга, захирал /иргэн, эрхлэгч/-ын нэр, холбоо барих утасны дугаар:	
Удирдамжийн дугаар	
Хяналт шалгалтын төрөл	
Хяналт шалгалт хийсэн огноо	

**2.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ:**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Шаардлага хангасан эсэх		Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Хангасан	Хангаагүй	
	1	2	3	4	5
1	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.3	Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, хийц, бүтээц, зориулалтыг өөрчлөх, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж суурилуулах, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэхдээ эрх бүхий хуулийн этгээдээр галын аюулгүй байдлын магадлал хийлгэсэн зураг төслийг баримталсан эсэх			
2	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.4	Ажилтан, алба хаагчийг гал түймрээс урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлсэн эсэх			
3	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.6	Гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмж, анхан шатны багаж хэрэгсэл, бодис,			

		материал зэрэгт техникийн үйлчилгээ хийж, ашиглалтын бэлэн байдлыг бүрэн хангасан эсэх			
4	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.9	гал түймрийн аюулын үнэлгээг энэ хуулийн 18.5, 18.6, 18.7, 18.8-д заасны дагуу хийлгэсэн эсэх			
5	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.2.10	Галын аюулгүй байдлын дүрэм, гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий этгээдээр баталгаажуулсан эсэх			
6	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.3	Аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хяналтын бүртгэл хөтөлсөн эсэх			
7	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 18.3	Гал түймэр унтраах автомашин чөлөөтэй хүрэлцэн очих замтай эсэх			
8	Засгийн газрын 2021 оны 211 дугаар тогтоолын хавсралт Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм	Барилга байгууламжид улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авсан, үүрэг даалгаврын биелэлт баталгаажсан эсэх			
9	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 5.1	Зүсмэл модон материалын агуулахын барилга нь нэг дан, галд тэсвэршилтийн IV-өөс багагүй зэрэглэлтэй, бүтээцийн галын аюулгүйн С0, С1 ангилалд тохирсон байх ёстой.			
10	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 5.2	Барилга доторх зүсмэл модон материалын хураалтын өндөр нь 5,5 м-ээс илүүгүй үед бүлэглэн хураасан талбай 600 м2-ээс ихгүй байна. Хураасан бүлгүүдийг тууш болон хөндлөн чиглэлд 5 м-ээс багагүй өргөн зурвасаар тусгаарлана.			
11	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 5.3	Зүсмэл модон материалын агуулахын барилгыг тусдаа талбайд байрлуулбал зохино. Зүсмэл модон материалын агуулахын барилга болон саравчийг зүсмэл материалыг ил хураасан талбайд байрлуулахыг зөвшөөрнө. Эдгээр барилга нь гал тэсвэршилтийн IV-өөс багагүй зэрэгтэй, мөн бүтээцийн галын аюулгүйн С2, С3 ангилалтай байна. Агуулахын барилга болон саравчаас ил зүсмэл модон материалын			



		хураалт хүртлэх галын зурвасын хэмжээ 30 м-ээс багагүй байна.			
12	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 5.5	Зүсмэл модон материалын агуулахын барилга болон саравчнаас үйлдвэрийн бусад барилга байгууламж хүртэлх зай 1 дүгээр хүснэгтэд заасан хэмжээнээс багагүй байна.			
13	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 5.6	Зүсмэл модон материалын агуулахын барилга болон саравчны бүх уртын дагуу гал түймэр унтраах үндсэн болон тусгай зориулалтын машин явах маневр хийх боломжтой 3м-ээс багагүй өргөнтэй, хатуу хучилттай орц гарц бүхий замыг төлөвлөнө. Тэхдээ 18 м хүртэлх өргөнтэй барилга ба саравчинд нэг талын, 18 м-ээс дээш өргөнтэй барилга ба саравчинд хоёр талын зам төлөвлөнө.			
14	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 5.7	Гал унтраах усны гадна хоолойг 12.4-р зүйлд заасны дагуу, доторх шугамыг 12.5—р зүйлийн дагуу, гал түймэр унтраах автоматжуулсан төхөөрөмж болон автоматжуулсан галын дохиоллыг БНБД 21-04-05-д заасны дагуу хийнэ.			
15	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 6.1	Зүсмэл модон материалыг задгай хадгалах хураалтын бүлгийн талбай 1200 м <sup>2</sup> -аас ихгүй байна. Хураалтын бүлгийг хооронд нь галын аюулгүйн тууш болон хөндлөн зурвасаар тусгаарлана. Хураалтын тууш чиглэлийн галын аюулгүйн зурвасын өргөн нь хураалтын өндрийн 1.5-аас багагүй, хөндлөн зурвасын өргөн нь хураалтын өндрөөс багагүй байна.			
16	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 10.4	Гадна талын халаалттай буюу халаалтгүй битүү галерей, тавцангуудыг дотор талын гал унтраах усны хоолой болон галын автомат дохиоллоор тоноглоно.			
17	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 11.1	Модон материалын задгай агуулахын талбайг БНБД 21-04-05 болон энэхүү нормын дагуу гар ажиллагаатай зарлан мэдээлэгч бүхий хаягтай цахилгаан дохиолол төлөвлөвөл зохино.			
	"Модон материалын агуулах галын аюулгүйн норм" /БНБД 21-00-10/-н 11.5	Модон материалын агуулахын барилга болон саравчны гал түймрийг хүмүүст зарлан мэдээлэхдээ БНБД 21-01-02-ыг мөрдлөг			

		болгох бөгөөд задгай агуулахын талбайд диспечерийн чанга яригч эрж хайж журамлах холбоо, дуут дохиолол зэргээр мэдээлэнэ (дуут дохио, хонх гэх мэт).			
18	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.6	Барилга байгууламжид гал түймэр гарсан үед мэдээлэх холбоо, дохиоллын хэрэгсэлтэй байна.			
19	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.15	Галын аюулгүйн шаардлагын дагуу барилга байгууламжийн мод, төмөр, хийц бүтээц, даавуу, хөшиг зэрэг шатамхай эд зүйлийг галд тэсвэртэй бодист түрхлэг, нэвчилгээ хийсэн байх бөгөөд тухайн бодисын үйлчлэлийн хугацаа дууссаны дараа дахин боловсруулалт хийнэ. Галд тэсвэртэй бодисын үйлчлэлийн чанарыг техникийн үзүүлэлтэд заасан хугацаанд болон жилд 1 удаа шалгана.			
20	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.24	Эвдрэл гэмтэлтэй шатдаг хийн тоног төхөөрөмж ашиглах, ахуйн зориулалттай хийн тулга болон тосон дэн, дэнлүү, зул, лаа нь унахааргүй суурьтай, доошоо халах бололцоогүй хийцтэй байх бөгөөд модон эдлэл зэрэг шатдаг материалаас хажуу тийш 0.2м, доош 0.7м-ээс илүү зайтай байрлуулахыг хориглоно.			
21	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.35.1	Барилга байгууламжийн хоорондох галын аюулгүйн зайг бараа материал хураах, автомашины зогсоол болгох зэргээр ашигласан эсэх			
22	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.35.2	Барилга байгууламжийн ойр орчимд хялбар авалцан асах шатамхай шингэн, шахсан болон шингэрүүлсэн хийн савыг хяналтгүйгээр орхисон эсэх			
23	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.35.7	Зоорийн болон хагас зоорийн давхраас бие даасан гарцгүй, эсхүл гарц нь барилгын үндсэн шатнаас галаас хамгаалах хаалтаар тусгаарлагдаагүй тохиолдолд тухайн барилга байгууламжид аж ахуйн зориулалтын үйлдвэрлэл явуулсан эсэх			
24	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 2.35.8	Олон хүн байрлах барилгын дотоод засал чимэглэлд шаталтын нөлөөгөөр амьсгал боогдуулах хорт хий ялгаруулдаг барилгын материал ашигласан эсэх			



25	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 3.6	Аврах зам, гарцын гэрэлтэгч тэмдэг, тэмдэглэгээ нь цахилгаан тасармагц ослын тэжээлээс (өөр эх үүсвэрээс) тэжээгдэн автоматаар асч байхаар тоноглогдсон байна.			
26	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 3.13	Галын аюулгүйн дүрэмд тусгайлан зөвшөөрөөгүйгээс бусад тохиолдолд аврах зам, гарцын дагуу байрлах хаалга нь барилгаас гарах чиглэлийн дагуу онгойхоор төлөвлөгдсөн байна.			
27	Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм 8.27	Барилгын доторх галын гидрант (галын кран) нь байнгын даралттай, стандартад нийцсэн хайрцаг сав, хоолой, хушуутай байна. Хоолой нь усны шугам, галын хушуунд холбоотой байх бөгөөд эвхэлтийг жилд 1-ээс доошгүй удаа солино. Галын усны шугам, хоолойны холбох хэрэгсэл нь гал унтраах ангийн автомашин, багаж хэрэгслийг залган ажиллуулахад саадгүй байх шаардлагатай.			

Хяналт шалгалтын нэмэлт тэмдэглэл.....

Улсын байцаагчийн санал, дүгнэлт .....

Шалгуулагч этгээдийн санал, дүгнэлт .....

### 3.БАТАЛГААЖУУЛАЛТ:

Улсын байцаагчийн албан тушаал, нэр, гарын үсэг, тэмдэг	Шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг	Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хүлээн зөвшөөрсөн: шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тэмдэг
/ албан тушаал /	/ албан тушаал /	/ албан тушаал /
/ овог, нэр /	/ овог, нэр /	/ овог, нэр /
/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /	/ гарын үсэг, тэмдэг /